



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Мянган Угалзат ОНӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: У.Батчимэг
Утас: 88094175
цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
4.5.1 Завсрын аудитын талаар.....
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МЯНГАН УГАЛЗАТ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.ОТГОНТУЯА ТАНАА

2023.03.14 № 2/104
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Мянган Угалзат ОНӨААТҮГ нь ТУЗ-аас баталсан зорилт түвшин хангагдаагүй, тайланд он дамжсан насжилт өндөртэй 21.8 сая төгрөгийн авлага барагдаагүй, ажилчидтай холбоотой өглөг 5.7 сая, татварын өглөг 47.3 сая, НДШ өглөг 18.8 сая, Дансны өглөг 143.5 сая, мөн хөрөнгө бодитоор оршин байхгүй төгрөгийн өр төлбөр үүсгэн ажиллаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, заалтуудыг зөрчсөн, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Мянган Угалзат ОНӨААТҮГ-т нийгмийн даатгалын шимтгэл, татварын хэлтсийн өр шийдвэрлэх зорилгоор 62.5 сая төгрөгийг нэмэлт орлогын эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ховд аймгийн Дуут сумын Цагаанбургас багийн нутаг дэвсгэрт байрлах “Нэвтийн рашаан” амралтын газар нь 2022 оны 06 дугаар сарын 9-10-нд шилжих шөнө шатаж Мянган Угалзат ОНӨААТҮГ-т их хэмжээний хохирол учирсан байна. Үүнд: Барилга байгууламж 272.7 сая, машин тоног

төхөөрөмж 73.1 сая, тавилга эд хөгшил 31.6 сая, бараа материал 54.6 сая төгрөг нийт 432.1 сая төгрөгийн эд хөрөнгө шатаж үрэгдсэнийг данс бүртгэлээс хасах шийдвэр гаргуулах саналыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн ч холбогдох шийдвэр гараагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Мянган угалзат ОНӨААТҮГ нь 3 төрлийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр төлөвлөсөнөөс паркийн орлогын төлөвлөгөөг 49.6 хувиар давуулан биелүүлсэн бол Нэвт рашаан амралтын газар” нрв 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдөр тогны масс гарсантай холбоотой гал түймэр гарч шатсан тул үйл ажиллагааны орлого бүрдүүлээгүй тасарсан, ахуй үйлчилгээний ногоон барилгын түрээсийн орлогыг 33.4 хувиар тасарахад 2022 оны 09 сараас Наран уул хоршоо болж өөрчлөгдсөн нь орлого тасарахад нөлөөлсөн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	65,777.22	40,618.73
1.1.2	Дансны авлага	27,999,402.00	21,818,350.00
1.1.4	Бусад авлага	234,848.00	234,848.00
1.1.6	Бараа материал	64,928,639.63	72,696,439.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	96,597,127.58	94,555,408.36
1.2.1	Үндсэн хөрөнгө	466,123,532.89	373,579,431.74
1.2.2	Биет бус хөрөнгө	200,192,974.45	200,192,974.45
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	666,316,507.34	573,772.40
1.3	Нийт хөрөнгийн дүн	762,913,634.92	668,327,814.55
2.1.1.1	Дансны өглөг	109,718,340.48	143,521,031.00
2.1.1.2	Цалингийн өглөг	7,214,373.29	5,795,200.00
2.1.1.3	Татварын өр	59,941,421.49	47,307,910.28
2.1.1.4	НДШ - ийн өглөг	47,498,097.97	18,805,870.32
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	224,372,233.23	215,430,011.60
2.2	Өр төлбөрийн нийт дүн	224,372,233.23	215,430,011.60
2.3	Өмч	359,038,740.00	359,038,740.00
2.3.1	-терийн	359,038,740.00	359,038,740.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	548,238,206.00	548,238,206.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-368,735,544.31	-454,379,143.05
2.3.11	Эздийн өмчийн дүн	538,541,401.69	452,897,802.95
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	762,913,634.92	668,327,814.55

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	49,513,319.86	145,908,954.50
2	Борлуулалтын өртөг	24,128,042.81	174,838,524.24
3	Нийт ашиг (алдагдал)	25,385,277.05	-28,929,569.7
4	Түрээсийн орлого	25,301,500.00	0.0
9	Борлуулалт, маркетингийн зардал	21,055,712.80	0.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	181,442,172.25	56,714,029.00
11	Санхүүгийн зардал	784,000.00	0.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-40,032,000.00	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-192,627,108.00	-85,643,598.74
19	Орлогын татварын зардал	0.0	0.0
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-192,627,108.00	-85,643,598.74
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-192,627,108.00	-85,643,598.74
24	Орлогын нийт дүн	-192,627,108.00	-85,643,598.74

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2021оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	359,038,740.00	308,206,206.00	240,032,000.00	-176,108,436.12	731,168,509.88
2	Залруулсан үлдэгдэл	359,038,740.00	308,206,206.00	240,032,000.00	-176,108,436.12	731,168,509.88
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-192,627,108.00	-192,627,108.00
8	2021оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	359,038,740.00	308,206,206.00	240,032,000.00	-368,735,544.31	538,541,401.69
2	Залруулсан үлдэгдэл	359,038,740.00	308,206,206.00	240,032,000.00	-368,735,544.31	538,541,401.69
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-85,643,598.74	-85,643,598.74
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	359,038,740.00	308,206,206.00	240,032,000.00	-454,379,143.05	452,897,802.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	75,709,700.00	224,144,435.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	75,637,200.00	145,908,954.50
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	78,205,481.47
1.2	Мөнгөн зарлагын дүн	76,345,922.07	224,139,594.46
1.2.1	Ажиллагчдад төлсөн	12,933,107.00	74,807,948.21
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,536,000.00	53,150,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,099,479.00	39,833,303.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,601,340.00	6,547,750.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,966,200.00	12,888,900.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	667,941.66	31,061,375.12
1.2.9	Бусад мөнгөн зарлага	44,541,854.41	5,850,318.13
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-636,222.07	-25,158.49
3.1	Мөнгөн орлогын дүн	3,000,000.00	800,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,000,000.00	800,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	3,030,300.00	800,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,000,000.00	800,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-741,522.07	-25,158.49
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	807,299.29	65,777.22
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	65,777.22	40,618.73

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мянган угалзат ОНӨҮГ нь "Ажилчдыг аюулгүй орчинд сэтгэл хангалуун ажиллах, өсөж дэвших боломжоор хангахын зэрэгцээ үйлчлүүлэгчдийн шаардлагад нийцүүлэн чанартай үйлчилгээ үзүүлэх" гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ховд аймаг дахь Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухайн хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Татварын тухай хууль, Аж, ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, Дотоод аудитын албанаас 2022 онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Мянган Угалзат ОНӨААТҮГ" нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мянган Угалзат ОНӨААТҮГ тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94,585.8 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	65.7	40.6	-25.1

Авлага	31,602.7	21,818.3	-9,784.4
Бараа материал	64,928.6	72,696.4	7,767.8
Үндсэн хөрөнгө	666,316.6	573,772.5	-92,544.1
Нийт хөрөнгө	762,913.6	668,327.8	-94,585.8
Өр төлбөр	224,372.2	215,430	-8,942.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	538,541.4	452,897.7	-85643.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	762,913.6	668,327.8	-94,585.8

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 40.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 25.1 мянган төгрөгөөр буурсан байна.
- ✓ Авлага 9,784.4 мянган төгрөгөөр буурсан бөгөөд дансны эцсийн үлдэгдэл дэх 21,818.3 мянган төгрөгийн 3,550.0 мянган төгрөгийг 2023 онд барагдуулан ажиллах боломжтой, 18,267,8 мянган төгрөг нь насжилт өндөртэй барагдахгүй авлага байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7,767.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалын үлдэгдэл байна.
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оноос 92,544.1 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч данс нь хуримтлагдсан элэгдлийн зардал нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Ховд аймаг дахь Мянган Угалзат ОНӨААТҮГ нь 2022 оны төсвийн төслийг дээд шатны байгууллагад нийт орлого 323.6 сая төгрөгөөр төлөвлөж нийт зардлаа 366.6 сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөн дээд шатны байгууллагад уламжилжээ.

№	үзүүлэлт	2022 он		Харьцүүлалт	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Нийт орлого	323,632.0	145908.9	(177,723.1)	45.08
	Үйл ажиллагааны бусад орлого	323,632.0	145908.9	(177,723.1)	45.08
2	Нийт зардал	366556.7	231552.5	(135,004.2)	63.17
	Үүнээс Удирдлагын зардал		56,714.0	56,714.0	0
3	татварын өмнөх ашиг	(42,924.7)	(85,643.6)	(42,718.9)	(18.08)
	Цэвэр ашиг /алдагдал/	(42,924.7)	(85,643.6)	(42,718.9)	(18.08)
	Нийт цалингийн сан	107,616.0	89384.9	(18,231.1)	83.06

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас баталсан байна.

Үзүүлэлт	2022 оны төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Хувь
Нийт орлого	323,632.00	160,499.85	49.6
Паркийн орлого	88,192.00	131,977.00	149.6
Рашаан амралтын орлого	125,440.00	-	-
Түрээсийн орлого	42,800.00	28,522.85	66.6
Дулаан түрээс	67,200.00	0	0

Мянган угалзат ОНӨААТҮГ нь 3 төрлийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр төлөвлөсөнөөс паркийн орлогын төлөвлөгөөг 49.6 хувиар давуулан биелүүлсэн бол Нэвт рашаан амралтын газар” нь 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдөр тогны масс гарсантай холбоотой гал түймэр гарч шатсан тул үйл ажиллагааны орлого бүрдүүлээгүй тасарсан, ахуй үйлчилгээний ногоон барилгын түрээсийн орлогыг 33.4 хувиар тасарахад 2022 оны 09 сараас Наран уул хоршоо болж өөрчлөгдсөн нь орлого тасарахад нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд аймгийн “Мянган Угалзат ОНӨААТҮГ”-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор У.Батчимэг 2022 оны 03 дугаар сарын 10-наас 03 дугаар сарын 13-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 231.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь

15 дугаар зүйлд заасан бусад хангамжийн материал, нормын хувцас худалдан авах зардалд 2.1 сая төгрөг, ажилчдын амралт, аяллын зардалд 3.1 сая төгрөг зарцуулсныг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан хяналт шалгалт хийж төлбөрийн акт тогтоосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 166 мэдээллээс 121 мэдээллийг хугацаандаа оруулсан 45 мэдээллийг хугацаа хоцроосон бусад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж 18.9 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	329,800.0	1	62,500	18.9
Нийт дүн	3	329,800.0	1	62,500	18.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өр төлбөр, авлага барагдуулсан эсэхэд нарийн хяналт хийх нарийн авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар 215.4 сая төгрөгийн өглөг, 21.8 сая төгрөгийн авлага барагдуулан ажиллах албан шаардлага өглөө.

5.1. Албан шаардлага

5.1.1 Авлага, өглөгтэй холбоотой

Мянган Угалзат ОНӨААТҮГ нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд он дамжсан насжилт өндөртэй 21.8 сая төгрөгийн авлага барагдаагүй, ажилчидтай холбоотой өглөг 5.7 сая, татварын өглөг 47.3 сая, НДШ өглөг 18.8 сая, Дансны өглөг 143.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн он дамжин бүртгэгдэж өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"заалтыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Авлага, өглөгийн барагдуулан ажиллаагүй, Үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бодитой оршин байхгүй	1	237,248.3			1	237,248.3					-	-	-	-
Дүн	1	237,248.3	0	0.0	1	237,248.3								-

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

А.ЦЭЦЭГСҮРЭН

У.БАТЧИМЭГ





ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 21/2023/1039

Ховд

ХОА-2022/05/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланд он дамжсан, насжилт өндөртэй 21,818.3 мянган төгрөгийн авлага, 215,430.0 мянган төгрөгийн өр төлбөр барагдахгүй он дамжин бүртгэгдэж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Насжилт өндөртэй он дамжсан 21,818.3 мянган төгрөгийн авлагыг шүүхийн байгууллагад хандаж барагдуулан ажиллах.
2. Он дамжин бүртгэгдэж байгаа 215,430.0 мянган төгрөгийн өр төлбөрийг ТУЗ-өөр хэлэлцүүлэн холбогдох газруудад уламжилж шийдвэрлүүлэн ажиллах.
3. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын дарга Д.Отгонтуяа, нягтлан бодогч Д.Санжидмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БОРДБААТАР
АУДИТОР  У.БАТЧИМЭГ

¹ Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545